

## 2019-2020 оны жилийн тайлан гарлаа

AMEP 2 хөтөлбөр эхний жилийн тайлангаа хүргэж байна. “Бид 2019-2020 онд төлөвлөсөн төсөл, ажлаа амжилттай хэрэгжүүлж, өргөн хүрээнд хамтын ажиллагаагаа бэхжүүлж, ирэх жилүүдийн амжилт, бүтээлийн сууриа тавилаа” хэмээн хөтөлбөрийн Захирал Кирстен Ливермор хэлсэн. AMEP 2 хөтөлбөрийн хэрэгжүүлсэн төслүүд МУ-ын эрдэс баялгийн салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад дараах байдлаар хувь нэмэр оруулжээ.

- > - МУ ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний кодтой болох ажлыг эхлүүллээ. Хөрөнгийн үнэлгээний код нь ЗГ, хувийн хэвшлийн зөвшилцөл хийх үйл явцыг хялбар дөхөм болгоно.
- > ТЭЗҮ-тэй холбоотой дүрэм журмыг шинэчилснээр ТЭЗҮ батлах үйл явцыг илүү үр дүнтэй болгоно.
- > МонГеоКат системийн мэдээллийг цахимжуулж, хэрэглэгч гео мэдээллийг хялбар, шуурхай хүлээн авах боломжтой боллоо.
- > Нүүрсний давхаргын метан хийн болон бусад ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайн давхцалтай холбоотой Австрали, МУ-ын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэлээ.
- > МУ дахь уурхайн хаалт болон нөхөн сэргээлттэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн стандартыг хэрхэн ашиглах удирдамж боловсрууллаа.

КОВИД-19 цар тахлаас үүдэн зарим төслийн хугацаа хойшилж, хил хаасантай холбоотойгоор өөрчлөлтүүд хийх шаардлага гарсан. Та бүхэн дэлгэрэнгүй тайлан, бусад судалгаа, илтгэлийг [amep.mn](http://amep.mn) цахим хуудсаас үзээрэй.

## Гүйцэтгэлийн хураангуй

2019-2020 онд AMEP 2 зургаан төсөл шалгаруулан хэрэгжүүллээ. Төсөл тус бүр судалгаа нотолгоонд суурилсан, мөн эрдэс баялгийн салбар дахь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад хувь нэмэр оруулахад чиглэгдсэн.

### Төсөл 1. Монгол Улсын ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний кодекс боловсруулах (МОНВАЛ)

- > Үр дүн: МУ олон улсын сайн туршлагад нийцсэн ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний кодекстой болох.

### Төсөл 2. Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, хүлээн авах журмыг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх

- > Үр дүн: ТЭЗҮ-ийн журмыг шинэчлэх, мөрдөж эхлэх; ТЭЗҮ боловсруулах, хүлээн авах, батлах үйл явцыг хялбар түргэн, шуурхай, тодорхой болгох.

### Төсөл 3. МУ-ын геологийн мэдээллийн каталог системд мэдээлэл оруулахад дэмжлэг үзүүлэх

- > Үр дүн: МонГеоКат систем бүрэн хэмжээнд ажиллаж, тогтмол шинэчлэгдэж, хэрэглэгч, хөрөнгө оруулагчдад цахимаар мэдээллийн хураангуйг хүргэдэг боллоо.

### Төсөл 4. Монгол дахь уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн үеийн нябо бүртгэлийн аргачлал боловсруулах

- > Үр дүн: Уурхайн компаниудын санхүүгийн тайлан МУ-ын нягтлан бодох бүртгэлийн стандарт, нөхөн сэргээлт, хаалтын журамд нийцсэн байх ёстой. Энэ чиглэлд Сангийн Яамтай үр дүнтэй хамтран ажиллаж байна.

### Судалгааны төсөл 1. Нүүрсний давхаргын метан хий – Австралийн эрх зүйн орчин, зохицуулалт

- > Нүүрсний давхаргын метан хий ашиглах, эрх зүйн зохицуулалт хийх шаардлага гарахад хэрэглэж болох суурь судалгааг энэ төслийн хүрээнд хийлээ.

AMEP 2 хөтөлбөрийн 2019-2020 оны жилийн тайланг бүрэн эхээр нь дараах холбоосоор үзнэ үү.

[http://www.amep.mn/news-detail/18?lang\\_id=1](http://www.amep.mn/news-detail/18?lang_id=1)

# АМЕП 2-ын боловсруулсан судалгаа тайлангууд

АМЕП 2-ын санхүүжүүлсэн төсөл бүр судалгаа, олон улсын тэргүүн туршлагад суурилсан тайланг Англи, Монгол хэл дээр боловсруулдаг. 2019-2020 онд бэлтгэн гаргасан бүх тайлан, судалгааг жагсаавал:

1. МОНВАЛ кодекс танилцуулах сургалтын илтгэл;
2. Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний олон улсын загвар болон таван улсын кодекст хийсэн харьцуулалт судалгаа;
3. Олон улсын ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний стандартын загвар;
4. Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний үндэсний кодекс нэвтрүүлэхтэй холбоотой эрх зүйн орчны судалгаа;

5. ТЭЗҮ боловсруулах олон улсын стандарт харьцуулалт;
6. ТЭЗҮ журам шинэчлэх ажлын хэсэгт танилцуулах санал;
7. ТЭЗҮ журмыг шинэчлэх үзэл баримтлал;
8. Хууль тогтоомжийн хийдлийн судалгаа;
9. Нүүрсний давхаргын метан хийн болон бусад ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайн давхцалтай холбоотой эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа.

Хөтөлбөрийн жилийн тайлан болон АМЕП-ийн хүрээнд бэлтгэсэн тайлан, судалгаануудыг [www.amep.mn](http://www.amep.mn) хуудсын Мэдлэгийн булан цэсээр орж, татан аваарай.

## НҮҮРСНИЙ ДАВХАРГЫН МЕТАН ХИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА ТАНИЛЦУУЛЛАА

АМЕП 2 төслийн Хуулийн зөвлөх Э. Ганбат “Нүүрсний давхаргын метан хий болон бусад ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайн давхцалтай холбоотой эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа”-гаа Монголын нүүрсний ассоциаци, Монголын нүүрсний давхаргын метан хийн холбоо болон салбарын төлөөлөгчдөд 2020.9.10-ны өдөр танилцууллаа. Илтгэлийг [amep.mn/news-detail/17](http://amep.mn/news-detail/17) хаягаар орж үзээрэй.

